

ЭМГ-ын 7 хоногийн мэдээ

I. Зарим статистик үзүүлэлтүүд

- Нийт төрөлт 55
- Амьд төрөлт 54
- Амьгүй төрөлт 1
- Дутуу төрөлт 2
- Нялхсын эндэгдэл 0
- 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0
- Эхийн ноцтой хүндрэл 0
- Төрөлхийн гажиг 0
- Гэрийн төрөлт 0
- Ихэр-0

-Ногооннуур сумд шинээр нээгдэж байгаа Айкемал эмийн санд үнэлгээ хийсэн.

-Улаанхус сумын Хөх хөтөл багын их эмчийн салбарт дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн.

-ӨЭМТүүдийн эмч нарын компьютерүүдийг интернетэд холбох цахим жор бичилтийн бэлтгэл ажлыг хангуулж байна

-Инкар үүдэн эмнэлэгт дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн.

-Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд аймгийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

-Бугат сумын иргэний Эрүүл мэндийн газарт өгсөн өргөдөл, гомдлын дагуу ажиллаж ЭМГ даргын зөвлөлийн хурлыг Бугат сумын ЭМТ-ийн их эмч О. Серижжаныг байлган хийж тус эмчид сануулах арга хэмжээ авсныг албан тоотоор өргөдөл өгсөн иргэнд хүргүүлэв.

-Улаанхус сумын ЭМТ-д 3,4 дүгээр саруудад хэвтэн эмчлүүлсэн 150 өвчний түүхийг хянаж зөвлөмж хүргүүлэв.

-Хөх хөтөл их эмчийн салбарт хэвтүүлэн эмчилсэн 41 өвчний түүхийг хянаж зөвлөмж хүргүүлсэн

- Буянт сумын 3 баг, Улаанхус сумын 2 дугаар багийн иргэдээс ирүүлсэн гомдлын мөрөөр ажиллаж хариу хүргүүлсэн.

2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Биелэлт
5	Нэгдсэн эмнэлгийн хашааны дотор байрлах Нийтийн бие засах газрын асуудлыг холбогдох байгууллагууд хамтран зөвшилцөж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах	ЭМГ-аас аймгийн нэгдсэн эмнэлгийн нийтийн бие засах газарт хяналт үнэлгээ хийж бие засах газрыг цаашид ашиглалтанд оруулах, халдвар хамгааллыг сайжруулах талаар нэгдсэн эмнэлгийн аж ахуйн дарга болон халдвар судлаач эмч нарт үүрэг өгч мэргэжлийн арга зүйгээр ханган албан даалгавар хүргүүлж ажилласан.

2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэхбайгууллага, албантушаалтан	Биелэлт
2	“Соёлтой хот” сарын аяны хүрээнд байгууллага тус бүридэвхтэй оролцож,гаднах орчныхоо талбайг цэвэрлэх, тохижилтыг сайжруулахаданхаарчажиллах	7 хоног	Бүх байгууллагуудын дарга нарт	2015.05.04-нд ЭМГ-ын нийт ажилчид байгууллагын орчин тойронд их цэвэрлэгээ хийсэн. Өдөр бүрийн байгууллагын жижүүрүүд цэвэрлэгээ хийж, дараагийн өдрийн жижүүрт хүлээлгэж өгч хэвшсэн болно. ЭМГ-ын ариун цэвэр хариуцсан ажилтнаар байгууллагын няравыг томилж ажиллуулж байна.
3	Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан хашаа барих ажлыг дуусгаж, байгууллага бүрмод тарих бэлтгэл ажлаа ханган ажилчдаа бүрэн оролцуулах	7 хоног	БОАЖГ-ын дарга, СДОА-ийн дарга болонхолбогдох бусад байгууллагуудын дарга нарт	

4	Тахлын өвчний талаар мэргэжлийн байгууллагуудын сургалт зохион байгуулагдах болсонтой холбогдуулан оролцох байгууллагууд үүргээ сайн биелүүлэн хариуцлагатай ажиллах	7 хоног	Холбогдох байгууллагуудын дарга нарт	ЭМГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын танилцуулга болон дадлага сургуулилтын бэлтгэл ажлын төлөвлөгөө, тушаалаар Ажлын дэд хэсэг байгуулах тухай А/21-р тушаал гаргаж ажлын хэсэг 3 удаа хуралдаж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2018 оны 05 дугаар сарын 10-нд ЗӨСТ нь Цагааннуур тосгонд нүүн шилжсэн болно. 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр ЭМГ-ын ажлын хэсэг Цагааннуур тосгонд ажиллахаар төлөвлөөд, ажил үүгийн хуваарь батлуулан ажиллаж байна.
---	--	---------	--------------------------------------	---

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 18 дугаар долоо хоногт нийт 4613хүн үйлчлүүлсний 143(3%)нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.7%-иарбуурсан үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (63)-ийн дотор 15 буюу 23.8%-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 9.7%-иар буурсан үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 308 дуудлагын 49 (15.9%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 4%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 18 дугаар 7 хоногт аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 18(100%) удаа ирүүлсэн байна.